

АГААР ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭ

Д/Д	№	Шийдвэрийн нэр, огноо дугаар	Заалтын агуулга	Тайлагнах байгууллага	Хэрэгжилт	Тухайн заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой нөхцөл байдал, учирч байгаа хүндрэл, цаашид авч хэрэгжүүлэх ажил	Дүгнэлт санал
	15	2017_03/03. Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай	3.1."Аймаг, нийслэлийн ИТХ-ын хуралдаанаар орон нутгийн орчны бохирдлын асуудлыг хэлэлцэн холбогдох арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх"	НЗДТГ	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн "Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 133 дугаар тогтоолын хүрээнд ногоон бүсийн 51080 өрхийн гэр, амины орон сууцны дулаалга, хатуу түлшний хэрэглээнд хяналт тавих Засгийн газрын гишүүдийн хуваарийг хавсралтаар баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид үүрэг болгосон. Мөн НИТХ-ын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 25/59 дүгээр тогтоолоор "Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхөд цахилгаан халаагуур болон бүх төрлийн хийн түлшээр ажилладаг төхөөрөмж суурилуулах, хэрэглээнд үнийн урамшуулал олгох журам"-ыг батлуулж, хатуу түлшний хэрэглээнээс татгалзсан өрхүүдэд цахилгаан болон бүх төрлийн хийн түлшээр ажилладаг тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийг нэг удаа	Ногоон бүсийн 51080 өрхийг цахилгаан болон хийд шилжүүлэх, дулаалгын төслийг хэрэгжүүлэхэд дүүргүүдээс нарийвчилсан судалгааг гаргах шаардлагатай байгаа бөгөөд судалгааны тоо баримтууд зөрөх, ажиллах хүчний тоо хэмжээг эцэслэн гаргах ажил удаашралтай байгаа болно. 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч дүүргүүдийн удирдлагуудтай хуралдаж судалгааг яаралтай эцэслэх үүрэг даалгавар өгсөн болно.	Ногоон бүсийн гэр, байшин сууцны дулаалгын ажил болон цахилгаан, хийд холбох ажлыг 2025.06.15-2025.09.15-ны өдрийн хооронд хийж дуусгахаар төлөвлөсөн тул байгууллагуудыг уялдаа холбоог сайжруулж, ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

17			үнэ төлбөргүй суурилуулах, халаалтын улирал болох 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 5 дугаар сарын 15-ны өдрийг дуустал нийт 9 сарын хугацаанд үнийн урамшуулал олгохоор бэлтгэл ажлыг хангаад байна.		
	3.2. Орчны бохирдлыг бууруулахад идэвхтэй оролцож хамтран ажиллах талаар нийт аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хандан уриалга гаргах	НЗДТГ	Тус газар нь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамтай хамтран Агаарын чанарыг сайжруулах бүсийн айл өрхүүдийг цахилгаан болон бүх төрлийн хийн халаагуурт үе шаттай шилжүүлэхтэй холбоотойгоор ногоон бүсэд хамаарах 51,000 айл өрхийн гэр, байшингийн дулаалга ажлын хүрээнд "Дулаан байшин" амины орон сууцны нээлттэй өдөрлөгийг 2025 оны 05 дугаар сарын 4-7-ны хооронд Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, нийт 12,000 гаруй иргэд олон нийтэд дулаалгын талаар танилцуулга мэдээлэл, 4000 гаруй ширхэг гарын авлага хүргэн ажилласан болно. Хагас жилийн байдлаар байгууллагын албан ёсны пэйж хуудасд Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, зөвлөмж мэдээ, мэдээллийг 20 инфографик зурагт хуудас, анэймэшн хэлбэрээр бэлтгэсэн 6 видео контент, мэргэжлийн байгууллага, иргэн, төрийн бус байгууллагын зөвлөгөө нийтлэл 4, сайн туршлагын талаар богино хэмжээний 1 видео контентыг байршуулж нийт 18,000 хүнд хүрсэн байна. Мөн Улаанбаатар хотын агаарын чанарын индексийн нийт 35 удаагийн мэдээг байршуулж ажилласан. Мөн News.mn, Medee.mn, Bolood.mn, Chig.mn зэрэг тус тус сайтуудаар Агаарын бохирдлын хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах, угаарын	Гадаа орчинд зохион байгуулагдаж буй арга хэмжээнүүд цаг агаарын нөхцөл байдлаас шууд хамааралтай бөгөөд энэ нь иргэдийн оролцоо, идэвхийг бууруулах шалтгаан болж байна. Зарим иргэдийн хувьд арга хэмжээний зорилго, ач холбогдлыг бүрэн ойлгоогүй, мэдээлэл дутмаг байдлаас шалтгаалан оролцоо, сонирхол багатай байх хандлага ажиглагдаж байсан. Иргэдийн цахим хэрэглээний түвшин харилцан адилгүй, ялангуяа ахмад настан болон мэдээлэл технологийн хүртээмжгүй бүсийн иргэдийн хувьд цахим орчны мэдээлэлд хүрч чадахгүй байх нөхцөл байдал байсаар байна.	Хатуу түлш хэрэглэхийг хориглосон ногоон бүсийг иргэдэд сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай. Олон нийтэд чиглэсэн мэдээллийг зөвхөн цахим орчноор бус уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэл, орон нутгийн сурталчилгааны сувгуудыг давхар ашиглан мэдээллийн тэгш хүртээмжийг хангаж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэднийг мэдээлэлд суурилсан зөв дадал, хандлагад уриалах сургалт, нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах.

			хийн хордлогоос урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж, мэдээлэл видео контент болон инфографик зурагт хуудсыг олон нийтийн хэрэгсэлээр түгээж нийт 60,000 гаруй иргэд олон нийтэд хүрсэн байна.	
--	--	--	--	--

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.МӨНХБААТАР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Г.АРИУНТУНГАЛАГ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ХАМТЫН
АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Г.ДӨЛГӨӨН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ТӨВӨЛЛӨГӨӨ, ТОГТООЛ
ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ө.МӨНГӨН-ЭРДЭНЭ